

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/127/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a> Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:narmandakhd@audit.gov.mn">narmandakhd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Батжаргал Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:batjargalb@audit.gov.mn">batjargalb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
5. Аудитын илрүүлэлт .....	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СС	Сангийн сайдын
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 170

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАЛХГОЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.МӨНХЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011022015

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>296,010,086.00</b>	<b>400,643,182.40</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	12,436,562.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	12,436,562.76
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	296,010,086.00	388,206,619.64
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,488,600.00	3,650,500.00
35110	Тусгай зориулалттай материал	1,488,600.00	3,650,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	88,937,768.00	153,972,401.64
35410	Бичиг хэргийн материал	458,100.00	419,500.00
35420	Аж ахуйн материал	81,385,668.00	146,231,901.64
35430	Сэлбэг хэрэгсэл	2,787,000.00	3,771,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,185,000.00	3,550,000.00
35600	Мал амьтад	205,583,718.00	230,583,718.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,196,033,955.08</b>	<b>4,075,018,668.45</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,196,033,955.08	4,075,018,668.45
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,805,918,072.00	3,685,480,468.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,168,642,208.06	1,564,277,799.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(272,431,808.96)	(311,104,376.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	251,065,097.00	409,108,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(157,872,628.79)	(164,044,081.31)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	246,585,240.00	252,082,195.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(130,133,990.34)	(121,664,935.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,611,924.33	184,811,793.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(113,750,895.70)	(104,572,913.57)
39209	Зам, гүүрийн байгууламж	453,318,589.00	473,318,589.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(221,250,098.62)	(248,746,285.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,371,736,523.00	2,933,075,959.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(959,602,086.98)	(1,181,062,075.10)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	390,115,883.08	389,538,199.89
39301	Програм хангамж	3,202,200.00	3,202,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,499,516.92)	(3,077,200.11)
39303	Бусад биет бус хөрөнгө	389,413,200.00	389,413,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,492,044,041.08</b>	<b>4,475,661,850.84</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>12,838,271.29</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	12,838,271.29
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	12,838,271.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	12,838,271.29
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,492,044,041.08</b>	<b>4,462,823,579.55</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,492,044,041.08	4,462,823,579.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,803,935,069.39	1,803,935,069.39
51101	Өмч: - төрийн	1,803,935,069.39	1,803,935,069.39
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,013,905,246.97	1,984,684,785.44
51210	Өмнөх үеийн үр дүн	2,224,369,074.63	1,013,905,246.97
51220	Тайлант үеийн үр дүн	(1,210,463,827.66)	970,779,538.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	674,203,724.72	674,203,724.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,492,044,041.08</b>	<b>4,475,661,850.84</b>

**Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,795,308,265.68</b>	<b>3,700,929,651.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>473,463,456.68</b>	<b>1,139,931,590.97</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>473,463,456.68</b>	<b>1,139,931,590.97</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,300,000.00	23,632,688.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,860,688.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	14,772,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	386,282,316.68	952,267,124.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	85,881,140.00	164,031,778.64
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,321,844,809.00</b>	<b>2,560,998,060.04</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>245,576,509.00</b>	<b>121,525,455.04</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,703,509.00	114,354,180.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,873,000.00	7,171,275.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,076,268,300.00</b>	<b>2,439,472,605.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	1,007,770,800.00	2,439,472,605.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,478,831,822.40</b>	<b>2,662,112,527.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,454,181,255.72</b>	<b>2,426,559,597.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,329,308,034.63</b>	<b>2,250,021,113.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>383,798,568.72</b>	<b>636,001,148.59</b>
210101	Үндсэн цалин	383,798,568.72	636,001,148.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,189,679.81</b>	<b>79,004,201.21</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,132,953.89	54,162,642.07
210202	Тэтгэмжийн даатгал	3,894,707.69	6,379,153.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,115,766.30	4,443,643.07
210204	Ажилгүйдлийн даатгал	731,477.52	1,431,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,314,774.41	12,586,962.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,113,862.68</b>	<b>42,177,027.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,298,862.68	11,179,527.94
210302	Түлш, халаалт	30,000,000.00	30,397,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,815,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>74,599,767.00</b>	<b>85,802,307.04</b>
210401	Бичиг хэрэг	1,920,000.00	3,939,300.00
210402	Тээвэр, шатахуун	66,447,967.00	38,874,980.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000.00	4,475,110.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	626,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,031,800.00	2,972,211.00
210408	Бараа материал акталсны зардал	-	34,914,006.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,423,100.00</b>	<b>12,452,100.00</b>
210604	Урсгал засвар	12,423,100.00	12,452,100.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>16,324,000.00</b>	<b>23,560,600.00</b>
210702	Дотоод албан томилголт	16,324,000.00	23,560,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,898,579.00</b>	<b>14,676,442.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,642,550.00	8,642,993.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	201,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,032.00	962,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	1,030,000.00
210807	Газрын төлбөр	459,747.00	3,730,249.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>732,360,477.42</b>	<b>1,356,347,287.17</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	354,389,301.70	837,130,267.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	553,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	377,971,175.72	518,663,519.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>124,873,221.09</b>	<b>176,538,483.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,842,600.00</b>	<b>55,633,499.98</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,842,600.00	24,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	30,883,499.98
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>106,030,621.09</b>	<b>120,904,983.31</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,030,621.09	120,904,983.31
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>24,650,566.68</b>	<b>235,552,930.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>24,650,566.68</b>	<b>235,552,930.00</b>
223001	Бусад хөрөнгө	24,650,566.68	235,552,930.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>316,476,443.28</b>	<b>1,038,817,123.77</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,526,940,270.94</b>	<b>68,037,585.29</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,464,609,130.94	40,984,187.29
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	62,331,140.00	27,053,398.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,526,940,270.94)</b>	<b>(68,037,585.29)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(1,210,463,827.66)</b>	<b>970,779,538.48</b>

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,323,144,809.00</b>	<b>2,584,630,748.04</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,300,000.00</b>	<b>23,632,688.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,300,000.00	23,632,688.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,300,000.00	23,632,688.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,860,688.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000.00	14,772,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,321,844,809.00</b>	<b>2,560,998,060.04</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	245,576,509.00	121,525,455.04
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,703,509.00	114,354,180.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,873,000.00	7,171,275.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,076,268,300.00</b>	<b>2,439,472,605.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,007,770,800.00	2,439,472,605.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,078,249,080.00</b>	<b>1,943,014,512.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,078,249,080.00</b>	<b>1,943,014,512.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>953,375,858.91</b>	<b>1,766,476,028.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>383,798,568.72</b>	<b>635,539,274.44</b>
210101	Үндсэн цалин	383,798,568.72	635,539,274.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,189,679.81</b>	<b>79,064,366.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,132,953.89	54,222,807.69
210202	Тэтгэмжийн даатгал	3,894,707.69	6,379,153.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,115,766.30	4,443,643.07
210204	Ажилгүйдлийн даатгал	731,477.52	1,431,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,314,774.41	12,586,962.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,113,862.68</b>	<b>42,177,027.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,298,862.68	11,179,527.94
210302	Түлш, халаалт	30,000,000.00	30,397,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,815,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>74,599,767.00</b>	<b>51,158,290.04</b>
210401	Бичиг хэрэг	1,920,000.00	3,939,300.00
210402	Тээвэр, шатахуун	66,447,967.00	38,874,980.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000.00	4,475,110.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	626,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,031,800.00	3,242,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>600,000.00</b>	<b>401,400.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	401,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,542,100.00</b>	<b>20,143,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,503,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	661,300.00
210604	Урсгал засвар	13,542,100.00	14,978,600.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>16,324,000.00</b>	<b>23,560,600.00</b>
210702	Дотоод албан томиллолт	16,324,000.00	23,560,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>21,898,579.00</b>	<b>22,191,442.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,642,550.00	16,157,993.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	201,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,032.00	962,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	1,030,000.00
210807	Газрын төлбөр	459,747.00	3,730,249.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>355,309,301.70</b>	<b>892,240,127.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	355,309,301.70	891,686,627.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	553,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>124,873,221.09</b>	<b>176,538,483.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,842,600.00</b>	<b>55,633,499.98</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,842,600.00	24,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	30,883,499.98
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>106,030,621.09</b>	<b>120,904,983.31</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,030,621.09	120,904,983.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>244,895,729.00</b>	<b>641,616,236.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>244,895,729.00</b>	<b>641,616,236.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>244,895,729.00</b>	<b>641,616,236.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>244,895,729.00</b>	<b>641,616,236.00</b>
223001	Бусад хөрөнгө	244,895,729.00	641,616,236.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(244,895,729.00)</b>	<b>(641,616,236.00)</b>

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,421,673,069.39	674,203,724.72	2,224,369,074.63	4,320,245,868.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,421,673,069.39</b>	<b>674,203,724.72</b>	<b>2,224,369,074.63</b>	<b>4,320,245,868.74</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	382,262,000.00	0.00	0.00	382,262,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,210,463,827.66	-1,210,463,827.66
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,803,935,069.39</b>	<b>674,203,724.72</b>	<b>1,013,905,246.97</b>	<b>3,492,044,041.08</b>
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,803,935,069.39</b>	<b>674,203,724.72</b>	<b>1,013,905,246.97</b>	<b>3,492,044,041.08</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,803,935,069.39</b>	<b>674,203,724.72</b>	<b>1,013,905,246.97</b>	<b>3,492,044,041.08</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	970,779,538.48	970,779,538.48
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,803,935,069.39</b>	<b>674,203,724.72</b>	<b>1,984,684,785.44</b>	<b>4,462,823,579.55</b>

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,751,128,900.00	2,463,105,293.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,961,992,600.00	1,821,489,057.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,905,151,100.00	1,644,950,573.71
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	719,266,100.00	635,539,274.44
210101	Үндсэн цалин	719,266,100.00	635,539,274.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	89,471,200.00	79,064,366.83
210201	Тэтгэврийн даатгал	60,839,500.00	54,222,807.69
210202	Тэтгэмжийн даатгал	7,157,900.00	6,379,153.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,726,500.00	4,443,643.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,431,800.00	1,431,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,315,500.00	12,586,962.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,990,000.00	42,177,027.94
210301	Гэрэл, цахилгаан	23,992,500.00	11,179,527.94
210302	Түлш, халаалт	30,397,500.00	30,397,500.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	45,070,500.00	44,210,310.00
210401	Бичиг хэрэг	3,949,900.00	3,939,300.00
210402	Тээвэр, шатахуун	31,927,000.00	31,927,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,324,700.00	4,475,110.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	626,700.00	626,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,242,200.00	3,242,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	401,400.00	401,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	401,400.00	401,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,147,300.00	20,143,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,503,600.00	4,503,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	661,300.00	661,300.00
210604	Урсгал засвар	14,982,400.00	14,978,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	21,718,600.00	21,480,600.00
210702	Дотоод албан томилолт	21,718,600.00	21,480,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,439,000.00	21,766,192.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,152,300.00	15,732,743.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	201,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	962,200.00	962,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,030,000.00	1,030,000.00
210807	Газрын төлбөр	3,750,900.00	3,730,249.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	923,647,000.00	780,167,902.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	923,093,500.00	779,614,402.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	553,500.00	553,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,841,500.00	176,538,483.29
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	56,841,500.00	55,633,499.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,750,000.00	24,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,818,400.00	30,883,499.98
<b>26</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	-	120,904,983.31
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	120,904,983.31
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>789,136,300.00</b>	<b>641,616,236.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	789,136,300.00	641,616,236.00
223001	Бусад хөрөнгө	789,136,300.00	641,616,236.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,751,128,900.00	2,463,105,293.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,727,978,900.00	2,451,874,293.00
122005	Улсын төсвөөс санхүүжих	2,727,978,900.00	2,451,874,293.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	23,150,000.00	11,231,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		
120010	Туслах үйл ажиллагааны орлого	23,150,000.00	11,231,000.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>121,525,455.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>121,525,455.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	121,525,455.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,947,980.04
210402	Тээвэр, шатахуун	6,947,980.04
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,080,000.00
210702	Дотоод албан томилолт	2,080,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	425,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	425,250.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	112,072,225.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,072,225.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>121,525,455.04</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>121,525,455.04</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,354,180.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,171,275.00

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 29,782.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 26,384.9 мянган төгрөгийг алдааг залруулж, 397.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

*Залруулсан алдаа:*

1. Аймгийн төсвөөс хэрэгжүүлсэн "Хүүхэд эрдэнэ" хүүхэд хамгааллын төслөөс олгосон 1,110.0 мянган тоног төхөөрөмжийг хөрөнгөд бүртгэж аваагүй байна.
2. НДШ, ХХОАТ тайлан, шилжүүлгийг зөрүүтэй тооцсоноос шалтгаалж ХХОАТ-ын 12.4 сая төгрөгийн авлага, НДШ-д 12.8 сая төгрөгийн өглөг үүссэнийг тусгаагүй орхигдуулсан байна. Эдгээр алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. Үүнд: 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.

**5.1 Төлбөрийн акт**

Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч албан хаагчид 12 дугаар сард 40 хувийн нэмэгдэл цалин олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1. Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно. 2.2. Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно. гэж заасныг зөрчсөн тул илүү олгосон 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Зөвлөмж

1. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Хөтөлбөр арга хэмжээний зардлаас ахмадуудад 3.0 сая төгрөг буюу цалингийн сангийн 0.4 хувьтай тэнцэх хөрөнгөөр хүндэтгэл үзүүлсэн байна. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 ... төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална. Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.12 Төсвийн байгууллагын удирдлага нь ахмадын сан байгуулан ажиллуулах тухай тушаалыг баталж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт хүргүүлж, ахмадын сангийн дансыг нээлгэнэ. гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ахмадын сангийн дансыг нээлгэж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгө орлогод аваагүй.	1	1,110.0	1	1,110.0	-	-	1	1,110.0	-	-	-	-
НДШ, ХХОАТ тайлан, шилжүүлгийг зөрүүтэй тооцсон /ХХОАТ илүү/	1	12,436.6	1	12,436.6	-	-	1	12,436.6	-	-	-	-
НДШ, ХХОАТ тайлан, шилжүүлгийг зөрүүтэй тооцсон /НДШ дутуу/	1	12,838.3	1	12,838.3	-	-	1	12,838.3	-	-	-	-
	<b>3</b>	<b>26,384.9</b>	<b>3</b>	<b>26,384.9</b>	-	-	<b>3</b>	<b>26,384.9</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

**Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	397.8	1	397.8	-	-	-	-	-	-	-	-
Ахмадын сангийн журмыг мөрдөөгүй.	1	3,000.0	-	-	-	-	1	3,000.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,397.8</b>	<b>1</b>	<b>397.8</b>	-	-	<b>1</b>	<b>3,000.0</b>	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 05 2024-2025/127/НА-СТА-ТШЗ

Чойболсан хот

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч албан хаагчид 12 дугаар сард 40 хувийн нэмэгдэл цалин 397.8 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1 "Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно.", 2.2 "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 397,800 /гурван зуун ерэн долоон мянга найман зуу/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Халхгол сумын Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхчимэг, нягтлан бодогч О.Болормаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

Б.БАТЖАРГАЛ



2125050014

